



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 онь 05 сарын 02 өдөр

Дугаар А/235

Хэрлэн сум

Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын сургалт  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”, Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын нэгдсэн сургалтыг 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсугай.
2. Сургалтыг зохион байгуулах албан тушаалтнууд болон сургалтад хамрагдах цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын нэгдсэн сургалтыг Хууль сахиулах байгууллагуудын сургалтын төвд зохион байгуулах нөхцөлөөр хангахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Батсайхан)-т, сургалтын төвийн салааны захирагч, гамшгаас хамгаалах бэлтгэлийн сургагч багш нарыг томилж ажиллуулахыг Онцгой байдлын газар, (хурандаа Ж.Эрдэнэбат)-т, Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/211 тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж, “Гучин сая мод” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Н.Хүрэлээ)-т, сургалт зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийг олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010037